

## **ӨСГӨВРИЙН ХӨРӨНГӨ БҮРТГЭХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжийн шаардлагад нийцсэн дотоодын үйлдвэрийн болон импортын өсгөврийн хөрөнгө бүртгэх, нийтийн хэрэгцээнд гаргах, бүртгэлийг шинэчлэх, бүртгэлээс хасахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Өсгөврийн хөрөнгийг Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /цаашид “яам” гэнэ/ цаасан болон цахим хэлбэрээр бүртгэж, нээлттэй мэдээллийн сан үүсгэнэ.

### **Хоёр. Дотоодод үйлдвэрлэсэн өсгөврийн хөрөнгийн бүртгэл**

2.1. Хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (цаашид “яам” гэх) нь шаардлага хангасан дотоодын үйлдвэрлэлийн өсгөврийн хөрөнгийг бүртгэх “Өсгөврийн хөрөнгийн бүртгэл” (цаашид “бүртгэл” гэх)-д цахимаар эсхүл цаасаар бүртгэнэ.

2.2. Өсгөврийн хөрөнгө бүртгүүлэхэд дараах материалыг бүрдүүлж цахим болон бичгээр яаманд ирүүлнэ. Үүнд:

2.2.1. Дотоодод үйлдвэрлэсэн өсгөврийн хөрөнгийг бүртгүүлэх тухай өргөдөл (Хавсралт 1);

2.2.2. Өсгөврийн хөрөнгө ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн мэдээ, тэмдэглэл;

2.2.3. Өсгөврийн хөрөнгийг баталгаажуулсан гэрчилгээ /дугаар, хүчинтэй хугацаа/;

2.2.4. Өсгөврийн хөрөнгийн түүхий эд бүтээгдэхүүний орц, найрлагын хувь хэмжээг тогтоосон тухай тэмдэглэл;

2.2.5. Өсгөврийн хөрөнгийн болон бүтээгдэхүүний танилцуулга;

2.3. Өсгөврийн хөрөнгийн бүртгэлээс хасах;

2.4. Өсгөврийн хөрөнгийн бүртгэлийн хугацааг сунгах;

2.8. Яам энэ журмын 2.2-т заасан шийдвэр, холбогдох бичиг баримтыг ажлын 10 хоногт багтаан хянаж, шаардлага хангасан тохиолдолд өсгөврийн хөрөнгийн бүртгэлийн хүчинтэй хугацааг 2 жилээр сунгана.

### **Гурав. Импортын өсгөврийн хөрөнгийн бүртгэл**

3.1. Өсгөврийн хөрөнгийг импортлох хүсэлтэй аж ахуйн нэгж нь импортын цэвэр өсгөврийн хөрөнгийн бүртгүүлэх тухай өргөдөл (Хавсралт 2)-ийг гаргаж, дараах бичиг баримтын хамт бүрдүүлж цахим болон бичгээр яаманд ирүүлнэ.

3.1.1. Экспортлогч улсын эрх бүхий байгууллага, олон улсын итгэмжлэлийн байгууллагын гишүүн байгууллагаар итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагаас тухайн өсгөврийн хөрөнгөнд олгосон хүчин төгөлдөр баталгаажуулалтын гэрчилгээний хуулбар, түүний баталгаат орчуулга;

- 3.1.2.Өсгөврийн хөрөнгө болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээ, мэдэгдэл, бүртгэлийн дугаарыг бүрэн харагдах бүтээгдэхүүний зураг;
  - 3.1.3.Өсгөврийн хөрөнгө импортлогчийн танилцуулга;
  - 3.1.4.Импортын өсгөврийн хөрөнгийн танилцуулга, импортлох тоо хэмжээ;
  - 3.1.5.Импортын бүтээгдэхүүний мэдээллийн монгол хэл дээрх орчуулга;
- 3.2.Импортын өсгөврийн хөрөнгийн бүртгэлээс хасах;
- 3.3.Импортын өсгөврийн хөрөнгийн бүртгэлийн хугацааг сунгах;
- 3.4.Яам дээрх журмын 3.1-т заасан холбогдох бичиг баримтыг ажлын 20 хоногт багтаан хянаж, шаардлага хангасан тохиолдолд өсгөврийн хөрөнгийн бүртгэлийн мэдээллийг шинэчилнэ.
- 3.5.Яам шинэчилсэн мэдээллийг хянаж, импортын өсгөврийн хөрөнгийн бүртгэлийн хүчинтэй хугацааг сунгах, хүчингүй болгох шийдвэр гаргана.

### **Дөрөв. Өсгөврийн хөрөнгийг нийтийн хэрэгцээнд гаргах**

- 4.1.Хүнсний худалдааны газар нь бүртгэгдсэн өсгөврийн хөрөнгийг нийтийн хэрэгцээнд нийлүүлж, худалдаална.
- 4.2.Хүнсний худалдааны газар нь цэвэр өсгөврийн хөрөнгийн хаяг бүхий худалдааны тасаг, буланд байршуулах ба бусад бүтээгдэхүүнээс тусгаарлаж, холбогдох хууль тогтоомжид заасан эрүүл ахуй, чанар стандартын шаардлага хангасан хадгалалт, тээвэрлэлтийн горимыг мөрдөнө.

### **Тав. Өсгөврийн хөрөнгө бүртгэхээс татгалзах, бүртгэлийг шинэчлэх, бүртгэлээс хасах**

- 5.1.Баримт бичгийг хуурамчаар үйлдсэн нь эрх бүхий байгууллагаас тогтоогдсон бол өсгөврийн хөрөнгө бүртгэхээс татгалзана.
- 5.2.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч, импортлогч, баталгаажуулалтын байгууллага нь мэдээллийн сан дахь өөрийн бүтээгдэхүүний талаарх мэдээлэлд өөрчлөлт оруулах хүсэлт гаргасан тохиолдолд бүртгэлийг шинэчилнэ.
- 5.3.Эрх бүхий байгууллагын шалгалтын дүн, шийдвэрийг үндэслэн өсгөврийн хөрөнгийг бүртгэлээс хасна.

### **Зургаа. Өсгөврийн хөрөнгөнд дугаар олгох**

- 6.1.Цэвэр өсгөврийн хөрөнгийн бүртгэлийн дугаар (Хавсралт 3) нь 3 үсэг, 3 тооноос бүрдэнэ.
- 6.2.Бүртгэлийн дугаарын 3 үсэг нь бүтээгдэхүүний гарал үүсэл, төлөвийг дараах байдлаар илэрхийлнэ:  
FPC - Foreign pure culture= импортын өсгөврийн хөрөнгө;  
LPC - Local pure culture =дотоодын үйлдвэрийн өсгөврийн хөрөнгө;
- 6.3.Бүртгэлийн дугаарын эхний гурван тоо нь барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн гадаад худалдааны барааны ангиллын тухайн бүтээгдэхүүнд хамаарах мөрийн дугаартай ижил байна.
- 6.4.Бүртгэлийн дугаарын тоо нь тухайн бүтээгдэхүүнийг бүртгэсэн хугацаа (он, сар)-г илэрхийлнэ.
- 6.5.Бүртгэлийн дугаарын тоо нь тухайн оноосон нэр бүхий өсгөврийн хөрөнгийн бүтээгдэхүүнд олгосон дугаар байна.

## ДОТООДОД ҮЙЛДВЭРЛЭСЭН ӨСГӨВРИЙН ХӨРӨНГӨ БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ

Өргөдлийн хэлбэр (холбогдох дөрвөлжинг тэмдэглэ)  
Шинээр бүртгүүлэх                      Бүртгэлийг шинэчлэх

<b>1. ХҮНСНИЙ ЧИГЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧИЙН МЭДЭЭЛЭЛ</b>				
Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн нэр				
Хаяг (цахим хаяг, холбоо барих утас, байршил)				
Мэргэжлийн хяналтын байгууллагаас хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид олгосон дүгнэлт эсхүл бүртгэлийн дугаар				
Өсгөврийн хөрөнгийн бүртгэл хариуцсан ажилтны овог нэр, албан тушаал, утас, цахим шуудангийн хаяг				
<b>2. ӨСГӨВРИЙН ХӨРӨНГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ</b>				
Өсгөврийн хөрөнгийн оноосон нэр				
Бүтээгдэхүүний төлөв, гадаад байдал, хэмжээ, савлагаа, жин				
Өсгөврийн хөрөнгийн орцын хувь хэмжээ, гр-аар	<10	11-50	51-99	100

..... (нэр) хүнс үйлдвэрлэгч миний Монгол Улсын өсгөврийн хөрөнгийг бүртгэлд бүртгүүлэхээр “Өсгөврийн хөрөнгийн бүртгэл”-д бүрдүүлж өгсөн бүх бичиг баримт үнэн болно.

..... гарын үсэг, тамга ..... он ..... сар ..... өдөр

.....(нэр) баталгаажуулалтын байгууллагыг төлөөлөх эрх бүхий ажилтан миний Монгол Улсын өсгөврийн хөрөнгийн бүртгэлд бүртгүүлэхээр “Өсгөврийн хөрөнгийн бүртгэл”-д бүрдүүлж өгсөн бүх бичиг баримт үнэн болно.

..... гарын үсэг, тамга ..... он ..... сар ..... өдөр

## ИМПОРТЫН ӨСГӨВРИЙН ХӨРӨНГИЙГ БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ

Өргөдлийн хэлбэр (холбогдох дөрвөлжинг тэмдэглэ)  
Шинээр бүртгүүлэх Бүртгэлд өөрчлөлт оруулах

<b>1. ЦЭВЭР ӨСГӨВРИЙН ХӨРӨНГИЙН ИМПОРТЛОГЧИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ</b>				
Нэр				
Хүнс импортлогчоос Мэргэжлийн хяналтын байгууллагад гаргасан мэдэгдлийн хуулбар				
Хаяг (цахим шуудангийн хаяг байршил, утас)				
Импортын өсгөврийн хөрөнгийн бүртгэл хариуцсан ажилтны овог нэр, албан тушаал, утас, цахим шуудангийн хаяг				
<b>2.ИМПОРТЫН ӨСГӨВРИЙН ХӨРӨНГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ</b>				
Импортын өсгөврийн хөрөнгийн оноосон нэр				
Үйлдвэрлэгчийн нэр, хаяг, экспортлогч улсын эрх бүхий байгууллагаас олгосон бүртгэлийн дугаар				
Сав баглаа боодлын шошгон дээрх тэмдэг, тэмдэглэгээ, мэдэгдэл				
Бүтээгдэхүүний төлөв байдал, савлагаа, жин, гадаад байдал				
Орцын хувь хэмжээ, гр-аар	<10	11-50	51-99	100
Гаалийн хилээр нэвтрэх боомтын нэр, хугацаа				
Тээврийн хэрэгслийн төрөл				

..... (нэр) өсгөврийн хөрөнгө импортлогч миний Монгол Улсын өсгөврийн хөрөнгийг бүртгэлд бүртгүүлэхээр “Өсгөврийн хөрөнгий бүртгэл”-д бүрдүүлж өгсөн бүх бичиг баримт үнэн болно.

..... гарын үсэг, тамга ..... он ..... сар ..... өдөр

## ӨСГӨВРИЙН ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛИЙН ДУГААРЫН ЖИШИГ ЗАГВАР

Үндэслэл	Товчлол	Тайлбар
Бүтээгдэхүүний гарал үүсэл	FPC LPC	Foreign pure culture= импортын өсгөврийн хөрөнгө; Local pure culture =дотоодын үйлдвэрийн өсгөврийн хөрөнгө;
БТКУС-ийн гадаад худалдааны барааны ангилалын тухайн бүтээгдэхүүнд хамаарах мөрийн 3 оронтой дугаар	000	Жишээлбэл: үхрийн махны хувьд 0210 гэсэн мөрийн дугаарыг хэрэглэнэ.
Бүртгэсэн он, сар	0000	Жишээлбэл: <b>1901</b> = 2019 оны 1 сар
Тухайн оноосон нэр бүхий цэвэр өсгөврийн хөрөнгөд олгосон дугаар	000	003 гэх мэт 3 цифрээр